

ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

/Автозам, төмөр зам хөндлөн гарах болон гүүрэн байгууламжид холбооны кабель шугамыг суурилуулах ерөнхий шаардлага MNS 6597:2016 стандарт/

№	Үзүүлэлт	Хуучин стандарт	Шинэчилж буй стандартын төсөл
1	Стандартын нэр	Автозам, төмөр зам хөндлөн гарах болон гүүрэн байгууламжид холбооны кабель шугамыг суурилуулах ерөнхий шаардлага	Холбооны кабель шугамыг Авто зам, төмөр зам хөндлөн гарах болон гүүрний байгууламжаар дамжуулан суурилуулах ерөнхий шаардлага
2	Стандартын хамрах хүрээ	<p>Энэ стандартаар холбооны кабель шугамын угсралт суурилуулалтын ажлыг хийхдээ автозам, төмөр зам болон гүүрэн байгууламжийг дайран гарахад тавигдах ерөнхий шаардлагыг тогтооход хамаарна.</p> <p>Энэ стандартыг автозамын гүүр байгуулах зураг төсөв боловсруулах мэдээлэл холбооны сүлжээний зураг төсөв боловсруулах, ашиглалт, суурилуулалт, техникийн засвар үйлчилгээ хийх аж ахуйн нэгж, иргэд мөрдөн ажиллана.</p>	<p>Энэ стандартаар холбооны кабель шугамын угсралт суурилуулалтыг авто зам, төмөр зам хөндлөн гаргах болон гүүрэн байгууламжаар дамжуулан гүйцэтгэхэд тавигдах ерөнхий шаардлагыг тодорхойлно.</p> <p>Энэ стандартыг авто зам, төмөр зам, гүүр байгуулах зураг төсөв боловсруулах, мэдээлэл холбооны сүлжээний зураг төсөв боловсруулах, авто зам, төмөр зам, гүүрийн байгууламжийн болон харилцаа холбооны суурилуулалт, техникийн засвар үйлчилгээ хийх аж ахуйн нэгж, иргэд мөрдөн ажиллана.</p> <p>Энэ стандартыг өндөржүүлсэн хиймэл саадыг хөндлөн гаргах эсвэл гудамж замын дагуу байрласан тусгаарлах зурвасын хэсэгт холбооны кабель шугамыг суурилуулалт хийхэд ашиглаж болно.</p>
3	Нэр томъёо, тайлбар	Нөөцийн нүх Буудаж гаргах Хамгаалалтын хоолой Сувагчлалын хоолой	Холбооны худаг Буудаж гаргах Цайрдсан төмөр хоолой Хамгаалалтын уян хоолой
4	Тавигдах шаардлагууд	Холбооны кабель шугамыг авто зам, төмөр замаар хөндлөн гаргах, гүүрээр суурилуулахад тавигдах шаардлагууд	<p>Норматив ишлэлд дурьдсан стандарт, зөвлөмж, үүрэн холбооны операторуудад мөрддөг дотоод дүрэм, норм, баримт бичгүүдийг судалсны үндсэн дээр дараах нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Практикт хамгаалалтын “ган хоолой” ашиглах боломжгүй байдгаас “galvanized steel pole” буюу цайрдсан төмөр хоолой ашиглахаар тусгасан. 2. Хамгаалалтын цайрдсан ган хоолойг авто зам, төмөр замын хөвөөний газрын гадаргуугаас доош ган 1.2 м-т суурилуулах байсныг 1.5м-т болгон өөрчилсөн. 3. Замын ус зайлуулах хоолой болон төмөр замын нүхэн гарц ашиглах аргыг шиггэр нэмж тусгасан. 4. Хот суурин газарт болон хот хоорондын автозам шинээр байгуулахдаа асфальтан хучилт

			<p>дор 50м тутам хамгаалалтын цайрдсан төмөр хоолой суурилуулах, түүнчлэн гүүрийн байгууламжид 1x4 цайрдсан төмөр хоолой суурилуулах шаардлагыг тогтоосон.</p> <p>5. Хот суурин газарт хамгаалалтын цайрдсан хоолойны эхлэл ба төгсгөлд холбооны худаг суурилуулах шаардлагыг тусгасан.</p> <p>6. Хүнд даацын автомашин зорчих автозамаар агаарын баганат шугамаар хөндлөн гаргах шаардлагын үүднээс 11 м-ийн өндөртэй агаарын багана ашиглах тухай тусгасан.</p>
5	Бусад		<ol style="list-style-type: none"> 1. Стандартын бүх зургуудыг инженерийн зурагчлалын аргаар шинэчлэн өөрчилсөн. 2. Стандартын найруулгыг шинэчилсэн. 3. Бүлэг хэсгүүдийн дугаарлалт өөрчлөгдсөн.